

Яаралтай тусламжийн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

- /1./ Гэмтсэн өвчтөнийг гэмтлийн байрнаас яаралтай холдуулах заалтанд хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- A. Галын аюул
 - B. Угаарын хий
 - C. Цус алдах
 - D. Дэлбэрэх
 - E. Живэх
- /2./ Осолдогч хахах шалтгаанд хамаарахгүйг нь заана уу?
- A. Хоол идэхийн өмнө болон идэж байх үед архи уух
 - B. Хоолны хатуу бүхэл хэсгийг муу зажилж залгихаар оролдох
 - C. Хиймэл шүдээ залгих
 - D. Ухаантай өвчтөн бөөлжих үед
 - E. Амандаа хатуу зүйл хийсэн үедээ инээх, гүйх, тоглох
- /3./ Гэмтсэн өвчтөнийг дуудахад хариулахгүй бол дэслэлийн дагуу хэрэгжүүлэх анхны арга хэмжээг сонгоно уу?
- A. Осолдогч амь тэнссэн байдалд ороогүй байна гэж үнэлнэ
 - B. Амьсгалын замыг чөлөөлнө
 - C. Амсгалуулна
 - D. Тусламж дуудна
 - E. Цус эргэлтийн байдлыг үнэлнэ
- /4./ Хүүхдийн яаралтай тусламжийн үед эмнэлзүйн ямар тохиолдолд аврах амьсгалуулалтыг хийх вэ?
- A. Ухаантай, амьсгалын дутагдалтай
 - B. Ухаанүй
 - C. Ухаангүй, амьсгалын дутагдалтай
 - D. Ухаагүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэнэ
 - E. Ухаагүй, амьсгал зогссон, судасны лугшилт тэмтрэгдэхгүй
- /5./ Осолдогч хүзүүний нугалам, нурууны гэмтэлтэй байх үед ойр зуур зөөж холдуулахад ямар аргыг сонгох вэ?
- A. Нэг аврагч сугадаж
 - B. Хоёр аврагч сугадаж
 - C. Нэг аврагч үүрч
 - D. Хоёр аврагч чагталсан гар дээр өргөх

- Е. Хувцасных мөрнөөс зөөлөн чирэх
- /6./ Өвчтөн амь тэнссэн байдалд ороогүй хөнгөвтөр гэмтэл авсан үед анхааран ажиллах хамгийн чухал зүйл юу вэ?
- А. Гэмтлийн байрнаас зөөж холдуулах
 - В. Ар гэрийнхэнд мэдэгдэх
 - С. Ажлын газарт нь дуулгах
 - Д. Өвчтөний биеийн байдлыг хүндрүүлж болох гэмтлийг илрүүлж анхны тусламж үзүүлэх
 - Е. Ойрын эмнэлэгт тээвэрлэн хүргэх
- /7./ Хахаж дугарч, амьсгалж чадахгүй, ухаантай байгаа осолдогчид үзүүлэх тусламжийн удирдамжид хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- А. Сээрэн дээр 5 удаа дэлсэх
 - В. Аюулхайг бүслэн шахах (5 удаа)
 - С. Дээрх ажилбарыг давтан хийх
 - Д. Амилуулах амьсгалуулалт хийх
 - Е. Амилуулах суурь тусламж эхлэх
- /8./ Амьсгалын дутагдлын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?
- А. Амьсгалын агаарын урсгалын чимээ шуугиж, хяхнаж сонсогдох
 - В. Айж бачимдах, хамрын угалз сарталзах, ам ангайх
 - С. Царай хөхөлбөр, баргар, хөлөрсөн
 - Д. Амьсгал давчидсан, олширсон
 - Е. Дээрх бигд
- /9./ Гуурсан хоолойн багтраа, гипервентиляци, анафилаксийн шок зэргийн үед бүгдэд нь адилхан илрэх ямар шинж байна вэ?
- А. Бүгдэд нь амилуулах амьсгалуулалт хийх заалттай
 - В. Зөвхөн хүүхдэд тохиолдоно
 - С. Бүгд амь тэнссэн байдлын илрэл
 - Д. Бүгдэд нь амьсгалын дутагдлын шинж илэрнэ
 - Е. Бүгдэд нь артерийн даралт нь буурна
- /10./ Амилуулах амьсгалуулалт зөв хийж байгааг илтгэх үзүүлэлтийг нэрлэнэ үү?
- А. Өвчтөний хацар томбойх
 - В. Өвчтөний аюулхай орчим цүрдийх
 - С. Амьсгалуултын үед өвчтөний хамраар агаар урсаж гарах
 - Д. Цээж тэлж, өвчүү өргөгдөх
 - Е. Хавирга завсрын булчин хонхойж сорогдох
- /11./ Өвчтөн осолдон байранд тусламж үзүүлж эхлэхээс өмнө заавал гүйцэтгэх ямар үйлдэл шаардлагатай вэ?
- А. Өвчтөнийг зөв байрлуулах
 - В. Ослын гэрчээс асуух
 - С. Тусламж дуудах
 - Д. Ослын орчныг үнэлэх
 - Е. Анхны тусламжийн цүнхээ шалгах
- /12./ Өдрийн хоолны үеэр таны найз гэнэт ханиалгаж, дуу нь суларч, хяхнах чимээ сонсогдов. Та ямар тусламж үзүүлэх вэ?
- А. Шалан дээр хэвтүүлээд, амыг ангайлгаж хуруугаараа гадны биетийг гогдож гаргахыг оролдоно
 - В. Шалан дээр хэвтүүлээд 2 удаа амьсгалуулж, 5 удаа аюулхай дээр нь дэлсэнэ
 - С. Сайн ханиалгаж, уртаар амьсгалахыг зөвлөнө
 - Д. Сээрэн дээр дэлсэх, аюулхайг бүслэн шахах ажилбарыг хэрэгжүүлнэ
 - Е. Толгойг гэдийлгэж, оочийг өргөж ажигбар хийнэ
- /13./ Өвчтөнөөс эмчид халдвар дамжих үйл явцад хамаарахгүй хүчин зүйлийг нэрлэнэ үү?
- А. Өвчтөн халдвар үүсгэгч нян, вирустай байх
 - В. Өвчтөний цус, шингэн эмчийн биед нэвтрэх зам байх
 - С. Өвчтөн эмгэг өвчнөөр халдварлагдсан өгүүлэмж
 - Д. Эмчийн биед халдвар үүсгэхүйц олон тооны нян нэвтэрч орох

- Е. Эмчийн дархлаа сул байх
- /14./ Амьсгалын дутагдалтай өвчтөн бүрт авч хэрэгжүүлдэг арга хэмжээг нь сонгоно уу?
- А. Амилуулах амьсгалуулалт хийнэ
 - В. Амны хөндийгээс соруулж цэвэрлэнэ
 - С. Өвчтөнд хүйтэн ус уулгана
 - Д. Өвчтөнийг тохиромжтой (суугаа) байрлалд оруулан, амраана
 - Е. Аюулхайг бүслэн шахах аргачлал
- /15./ Гэмтсэн өвчтөнөөс асууж цуглуулдаг өгүүлэмжид хамаарахгүйг нь тодруулна уу?
- А. Яаж гэмтсэн, юу тохиолдсон бэ
 - В. Биеийн аль хэсэгт өвдөж, хөндүүрлэж байна вэ
 - С. Харшилтай юу
 - Д. Архаг өвчний түүх
 - Е. Тогтмол хэрэглэдэг эмийн бодис
- /16./ Осолдсон хүнийг амь тэнссэн байдалд орсон эсэх үнэлгээнд хамаарахгүйг нь тэмдэглэнэ үү?
- А. Осолдогчтой харилцаж, дуудах
 - В. Ухаангүй байвал тусламж дуудах
 - С. Амьсгалын замыг чөлөөлөх
 - Д. Амьсгалалтыг чагнах
 - Е. Цус алдаж байгаа эсэхийг шалгах
- /17./ Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү?
1. Өвчүү, цээжний тус газар дарж байгаа мэт
 2. Өвдөлт мөр, гарлуу дамжина
 3. Өвдөлт хүзүү, багалзуур, доод эрүүрүү дамжина
 4. Өвдөлт хавирганы завсарт зөвхөн нэг цэгт хүчтэй илэрнэ
 5. Өвдөлт амьсгал авах үед нэмэгдэнэ
- /18./ Өвчтөн Б 36 настай, бөөрний архаг дутагдлын улмаас гемодиализ 28 удаа хийлгэсэн боловч одоо юу ч хийгээд нэмэргүй гээд гэрт нь гаргасан. Түүний ухаан саруул, арьс, амьсгалаас шивтэр үнэртдэг ба бие нь маш их загатнадаг. Түүний бүх бие хавантай ба түүнд дотор муухайрах бөөлжих шинж маш ихээр илэрсэн тул идэж уух сонирхолгүй болсон. Түүний бөөлжих эмгэг жамд ямар нейротрасмиторууд оролцож байгаа вэ?
1. Допамин
 2. Гистамин
 3. Серотонин
 4. Холинэрг
 5. Простогландин
- /19./ Ерөнхий мэргэжлийн эмч амилуулах суурь тусламжаа зогсоох заалтууд
1. Тусламж үзүүлэгчид ослын орчны байдал аюултай болох
 2. Осолдогчийн амьсгалын үйл ажиллагаа сэргэх
 3. Дефибриллятортой аврах багийнхан хүрэлцэн ирэх
 4. Тусламж үзүүлэгч бүрэн цуцаж туйлдах
 5. Амилуулах тусламж үзүүлээд 30 минутаас илүү болох, хамтын шийдвэрийг үндэслэх
- /20./ Гэмтсэн өвчтөнийг шаардлаггүй үед хөдөлгөж, зөөхөд ямар сөрөг нөлөө гарч болох вэ?
1. Хугарсан яс арьсийг цоолох
 2. Хугарсан яс зөөлөн эд, судас гэмтээх
 3. Цус алдалтыг нэмэгдүүлэх
 4. Шарханд халдвар орох
 5. Өвдөлт нэмэгдүүлэх
- /21./ Гэмтсэн өвчтөн амь тэнссэн байдалд орсон шинжүүдэд хамаарахыг нь тэмдэглэнэ үү?
1. Ухаангүй
 2. Амьсгал саадтай (хяхнасан амьсгал)
 3. Амьсгалын тоо хэт цөөрсөн, олширсон, давчидсан
 4. Амьсгалын хөдөлгөөн ажиглагдахгүй

5. Их хэмжээний цус алдсан

/22./ Спиринолактоны (Верошпирон) шахмал хэдэн мг-тай байдаг вэ? Асциттай өвчтөнд хэдэн мг-аар уулгаж эхлэх вэ?

1. 5 мг-ын шахмал
2. 25 мг-ын шахмал
3. 1 шахмалаар уулгах
4. 100 мг-аар буюу 4 шахмалаар уулгах
5. 50 мг буюу 2 шахмалаар уулгах

/23./ Осолдогчид анхны тусламж үзүүлэхдээ халдвар авахаас хамгаалах арга хэрэгслэлүүдийг нэрлэнэ үү?

1. Хамгаалалтын бээлий өмсөх
2. Хамгаалалтын нүдний шил зүүх
3. Бээлий өмсхөөс өмнө бөгж, бугуйвч, цагаа тайлах
4. Амны хаалт зүүх
5. Гарын шарх, шалбархайд тусламж үзүүлж эхлэхээс өмнө наалдамхай (шархны) тууз нааж хамгаалах

/24./ Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү?

1. Цээжний өвдөх + амьсгал давчдах
2. Цээжний өвдөх + дотор муухайрч, бөөлжих
3. Цээжээр өвдөх+ толгой эргэх, муужрах
4. Цээжээр өвдөх + чацга алдах
5. Цээжээр өвдөх + хөлрөнө, арьс хөхрөнө, хөрнө

/25./ Ослолдсон хүнд тусламж үзүүлэх явцад эмчид учирч болох ямар эрсдэл байх вэ?

1. Халдвар авах
2. Зам тээврийн осолд өртөх
3. Хорт хийгээр амьсгалах
4. Архаг эмгэг өвчин тусах
5. Хахах

/26./ Зүрх зогсоход хүргэдэг осол гэмтлийн үндсэн шалтгаануудыг тэмдэглэнэ үү?

1. Зам тээврийн осол
2. Живэх
3. Угаартах
4. Хордох
5. Хахах

/27./ Амин эрхтэнд хамаарахыг нь сонгоно уу?

1. Амьсгалын зам
2. Амьсгалалт
3. Цус эргэлт
4. Элэг
5. Бөөр

/28./ Өвчтөн Б 36 настай, бөөрний архаг дутагдлын улмаас гемодиализ 28 удаа хийлгэсэн боловч одоо юу ч хийгээд нэмэргүй гээд гэрт нь гаргасан. Түүний ухаан саруул, арьс, амьсгалаас шивтэн үнэртдэг ба бие нь маш их загатнадаг. Түүний бүх бие хавантай ба түүнд дотор муухайрах бөөлжих шинж маш ихээр илэрсэн тул идэж уух сонирхолгүй болсон. Түүний бөөлжих эмгэг жамд ямар нейротрасмиторууд оролцож байгаа вэ?

1. Допамин
2. Гистамин
3. Серотонин
4. Холинэрг
5. Простогландин

/29./ 82 настай элэгний хавдартай өвчтөний хүчтэй өвдөлтийг намдаахаар Морфиныг 10 мг-аар 4 цагаар уулгаж эхэлсэн боловч, өвчтөн дэмийрч, хий зүйл харж, авцалдаагүй зүйл ярьж эхэлсэн. Өвчтөнд нас барах үеийн шинж илрээгүй. Энэ өвчтөнд хэрхэн туслах вэ?

1. Настай өвчтөнд Морфины эхлэх тун 5 мг байдаг тул Морфин уулгах тунг 5 мг болгож багасгах

2. Настай өвчтөнд Морфины метаболизм элгэнд удааширсан ба бөөрөөр ялгарах нь удааширсан байдаг тул Морфин уулгах цагийг холдуулах, 5 мг-аар хоногт 8-12 цагаар уулгах

3. Морфины хордлогыг тайлах зорилгоор физиологийн уусмал судсаар, эсвэл арьсан доор дуслаар хийх

4. Морфиныг хасах ба дахин хэрэглэхгүй байх

5. Өвчтөн нас барах гэж байгаа тул бүх эмчилгээг хасах.

/30./ Хахаж, ухаан алдаж унасан осолдогчийг аврах удирдамжид заасан аргачлалыг сонгоно уу?

1. Сээрэн дээр 5 удаа дэлсэх

2. Тусламж дуудах

3. Амилуулах амьсгалуулалт хийх

4. Амилуулах суурь тусламж эхлэх

5. Аюулхайг бүслэн шахах

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/31./ Амилуулах тусламж үзүүлэхэд цээжний шахалтын гүн насанд хүрэгчдэд хэдэн см вэ?

A. 4 см дээш

B. 3 см орчим

C. Хамгийн багадаа 6 см

D. Хамгийн багадаа 5 см

E. 4 см

/32./ Нярай хүүхдийн амьсгалын замыг чөлөөлөхөд та заавал

A. Толгойг гэдийлгэх, эрүүг өргөх, далан доор эвээс хийх

B. Амыг ангайлган, эрүүг өргөх

C. Үнэрлэх байрлалд оруулан, толгой доор эвээс хийх

D. D. Толгой хүзүү, цээжийг дундаж байрлалд оруулах

E. Толгойг гэдийлгэх

/33./ Чихрийн шижингийн комын эмчилгээний явцад гарч болох аюултай хүндрэлүүд юу вэ?

A. Гипогликеми

B. Гипокалиеми

C. Тархины хаван

- D. Амьсгалын хямрал
E. Бүх хариулт зөв
- /34./ Амилуулах суурь тусламжийг хэн үзүүлэх вэ?
A. Эмч, сувилагч
B. Эмнэлгийн бүх ажилчид
C. Насанд хүрсэн бүх хүн
D. Эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын албан хаагч
E. Дэргэд нь байгаа хэн бололцоотой нь
- /35./ Уушигны хаванг буулгах зорилгоор шээс хөөх эм хэрэглэдэг. Доорх эмээс алийг нь хэрэглэх вэ?
A. Маннитол
B. Лазикс
C. Верошпирон
D. Тэхийн шээг
E. Маннитол тарьж тэхийн шээг уулгана
- /36./ Ухаангүй өвчтөнд хамгийн түрүүнд үзүүлэх тусламж аль нь вэ?
A. А. Аюулыг зайлуулах
B. В. Хариултыг шалгах
C. С. Тусламж дуудах
D. D. Цээжинд шахалт хийх
E. E. Амьсгалын зам чөлөөлж амьсгал өгөх
- /37./ Архины хордлоготой ухаангүй хүнд нэн түрүүнд юу хийх вэ?
A. Шингэн сэлбэх
B. Анальгин , димедрол
C. Глюкоз, B1
D. B6
E. Реополиглюкин
- /38./ Амилуулах суурь тусламжийн үед Цээжний шахалтыг хамгийн багадаа хэдэн секунд завсарлах вэ?
A. 10 сек
B. 20 сек
C. 30 сек
D. 40сек
E. 15 сек
- /39./ Автомат тохируулгат дефибрилляторыг ховдлын жирвэлзлийн үед хэдэн минутын давталттай хэрэглэх вэ?
A. 1 мин
B. 2 мин
C. 3 мин
D. 4 мин
E. 5 мин
- /40./ АлАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?
A. Зүрхний шигдээс
B. Бөөр болон булчингийн гэмтэл
C. Элэгний үрэвсэл
D. Элэгний хатуурал
E. Цус задрал
- /41./ 60 настай эрэгтэй АД ихэсдэг.Сүүлийн үед даралт тогтвортой өндөр байгаа. Эхнэрийнхээ даралтын эмнээс уусан.Толгой эргэж дотор муухайрч огиулсан, амьсгал давчдана .Үзлэгээр тайван бус, хүйтэн хөлс нь гарсан, цонхийж цайсан, мөчид хүйтэн чийглэг, артерийн даралт буурсан, брадикардитай (40). Энэ ямар шокийн хэлбэр вэ ?
A. Гиповолемийн шок
B. Зүрхний шок

- C. Үжлийн шок
 - D. Анафилаксын шок
 - E. Бөглөрлийн шок
- /42./ Зүрхний цохилтын тоо хэдээс дээш гарах үед зүрхний булчингийн цус хомсрол элбэг тохиолдох вэ?
- A. > 110 удаа/мин
 - B. > 150 удаа/мин
 - C. > 180 удаа/мин
 - D. > 200 удаа/мин
 - E. > 250 удаа/мин
- /43./ Цусны эргэлтийг шалгах анхны тусламжинд сонгох арга
- A. Цээжийг чагнах
 - B. Хялгасан судасны эргэн дүүрэлтийг шалгах
 - C. Гүрээний артер дээр тэмтрэх
 - D. Өвчтөн хяналтын монитор холбох
 - E. Дээрх бүгд зөв
- /44./ Тархины хаван буулгах зорилгоор ямар арга хэмжээг хамгийн эхлэн авах вэ?
- A. Орны толгойг өндөрлөх
 - B. Фуросемид хийх
 - C. Дексаметазон хийх
 - D. Маннитол хийх
 - E. Полиглюкин хийх
- /45./ Насанд хүрэгчдийн амьсгалын замыг чөлөөлөх энгийн арга
- A. Эрүүг өргөх, толгойг өргөх
 - B. Толгойг гэдийлгэн, хэлийг татах
 - C. Толгойг гэдийлгэн эрүүг өргөх
 - D. Толгойг гэдийлгэн, амыг ангайлгах
 - E. Толгойг гэдийлгэх
- /46./ Сийвэнгийн К багасах шалтгаанд аль нь хамаарахгүй вэ?
- A. Их шээх
 - B. Бөөлжих
 - C. Хоол тэжээлээр орох К-ийн хэмжээ багасах
 - D. Их хөлрөх
 - E. Гүйлгэж суулгах
- /47./ Ухаангүй байдлыг яаж тодорхойлвол дээр вэ?
- A. Чихнээс чимхэх, өвтгөж үзэх
 - B. Нүүр лүү нь алгадах, мөрнөөс нь сэгсрэх
 - C. Дээрээс нь хүйтэн ус асгах
 - D. Өвчтөнд энгийн тушаал өгөх, мөрнөөс нь сэгсрэх, өвтгөж үзэх
 - E. Өвчтний даралтыг хэмжиж үзэх
- /48./ Судасны системийн ямар хэсэг нь судасны эсэргүүцлийг бүрдүүлэх вэ?
- A. Аорта
 - B. Дунд калибрийн артери
 - C. Вен
 - D. Капиляри
 - E. Артериол
- /49./ Насанд хүрсэн өвчтний улаан хоолой өргөссөн венээс цус алдах үеийн яаралтай тусламжийн аргад хамаарахгүйг нь сонгоно уу?
- A. Кальцийн бэлдмэл тарих
 - B. Улаан хоолойн өргөссөн венийг дурангаар боох
 - C. Блек-Морын зонд тавих
 - D. Дурангийн аргаар соривжуулах эмчилгээ хийх
 - E. Шингэн сэлбэх
- /50./ Хүчдэлт пневмотораксын үед зайлшгүй шаардлагатай нь:

- A. А. Хүчилтөрөгч эмчилгээ
 - B. В. Зохиомол амьсгал
 - C. С. Цээжний гялтангийн хөндийд хатгалт хийх
 - D. D. Зүрхэнд нөлөөлөх бэлдмэл хийх
 - E. E. Судас нарийсгагч хэрэглэх
- /51./ Ухаангүй амьсгалтай өвчтөнг орхиж явахаар бол яах вэ?
- A. Орхиод явна
 - B. Толгойг нь гэдийлгээд эрүүг нь өргөнө баруун хажуугаар хэвтүүлнэ
 - C. Хажуу тийш нь харуулж хэвтүүлээд дээд гарыг нь дэрлүүлж дээд хөлөөр нь тулж толгойг гэдийлгэн хэвтүүлнэ
 - D. Түрүүлгэнэ харуулан хэвтүүлж орхино
 - E. Хажуу тийш нь харуулж хэвтүүлнэ
- /52./ Тархины эдийн цус харвалттай өвчтний артерийн даралтыг барих түвшин
- A. Ирсэн түвшингөөс нь 30%-аар буулгах
 - B. Хэвийн хэмжээнд хүртэл буулгах
 - C. Агшилтын даралтыг 140-160 мм МУБ-ын хооронд барих
 - D. Артерийн даралтыг 40 мм МУБ-аар бууруулах
 - E. Артерийн даралтыг 20 мм МУБ-аар бууруулах
- /53./ Үхэдхийн унасан хүнд юуг шалгаж амилуулах тусламж үзүүлэхийг шийдэх вэ?
- A. Судасны лугшилт байгаа эсэх
 - B. Ухаан санааны байдал, амьсгал буйг шалгах
 - C. Судасны лугшилт, артерийн даралт үзэх
 - D. Ухаан санааны байдал, хүүхэн харааны байдлыг шалгаж
 - E. Артерийн даралт үзэх
- /54./ Ухаангүй хүнд сийвэнгийн чихэр үзэх боломжгүй бол глюкоз хэдэн граммыг тарьдаг вэ?
- A. 25гр
 - B. 50гр
 - C. 60гр
 - D. 40гр
 - E. 10гр
- /55./ Амилуулах тусламжийн дараалалын товчлол аль нь вэ?
- A. ABCD
 - B. ABC
 - C. SABD
 - D. CAB
 - E. CABD
- /56./ Амилуулах лавшруулсан тусламжинд хэрэглэх гол эм:
- A. Лидокайн
 - B. Дигоксин
 - C. Атрофин
 - D. Адреналин
 - E. Кальци хлорид
- /57./ АсАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?
- A. Зүрхний шигдээс
 - B. Баруун ховдлын дутагдал
 - C. Цус задрал
 - D. Вирусийн халдвар
 - E. Бөөр болон тархины гэмтэл
- /58./ Цээжний шахалтыг нэг минутанд хэдэн удаа хийх вэ?
- A. Нярайд 120, Хүүхдэд 100, том хүнд 70
 - B. Нярайд 100, Хүүхдэд 90, том хүнд 80 удаа
 - C. Бүх насанд адилхан 100-120
 - D. Нярайд 120, Хүүхдэд 100, том хүнд 100

- Е. Нярайд 100, Хүүхдэд, том хүнд 90
- /59./ Цээж шахалт хийхдээ
- А. Хатуу гадаргуу дээр хэвтүүлж 2 удаа амьсгал өгнө
 - В. Өвчүүний доод $\frac{1}{3}$ дээр гараа байрлуулж тохойн үеэр шулуун байлгаж цээжний хүчээр дарах
 - С. Өвчүү хавирганы заагт гараа байрлуулж атган хийнэ
 - Д. Өвчүүний голд гараа байрлуулж гаран дээрээ гараа давхарлан шахалтын гүн 8 см байхаар шахна
 - Е. Өвчүүний голд гараа байрлуулж гаран дээрээ гараа давхарлан шахалтын гүн 6 см байхаар шахна
- /60./ Бөөлжиж, чацга алдсан үед судсаар сэлбэх үндсэн шингэн болгон сонгон авах уусмал?
- А. Маннитол
 - В. 8,4%-ийн содын уусмал
 - С. Рингенийн уусмал
 - Д. 5% глюкоз
 - Е. Дескран
- /61./ Булчингийн их хэмжээний дарагдалтай өвчтөнд хамгийн олонтой тохиолддог хүндрэл юу вэ?
- А. Зүрхний дутагдал
 - В. Бөөрний дутагдал
 - С. Тархины хаваншил
 - Д. Элэгний дутагдал
 - Е. Бөөрний дээд булчирхайн дутагдал
- /62./ Хүзүүний гэмтэлтэй хүнд амьсгалын зам чөлөөлөх энгийн арга:
- А. Толгойг гэдийлгэн эрүүний шонтонгоос өргөх
 - В. Толгойг хөдөлгөөнгүй бэхлэн эрүүг доош нь болгох
 - С. Хүзүүг хөдөлгөөнгүй бэхлэн эрүүний өнцгөөс өргөх
 - Д. Толгойг хөдөлгөөнгүй бэхлэн барьж эрүүний өнцгөөс өргөн амыг ангайлгах
 - Е. Толгойг бөхтийлгөх
- /63./ Зүүн ховдлын дутагдлын эхэн үед ямар төрлийн гипокси үүсдэг вэ?
- А. Цус эргэлтийн
 - В. Гемоглобины
 - С. Хүчилтөрөгчгүйдлийн
 - Д. Эд хордлогын
 - Е. Эдийн
- /64./ Хохирогчийн амьсгал шалгах энгийн арга
- А. Цээж хөдлөж буйг харах, амнаас агаар гарч байгааг сонсох, мэдрэх
 - В. Хамар, аманд утас ойртуулж харах, гараар цээжин дээр дарж мэдрэх
 - С. Хэвлий цээжний хөдөлгөөнийг сайтар харах, хамарт гараа ойртуулах
 - Д. Өвчтний аманд лаа ойртуулж дөл нь хөдлөх эсэхийг харах
 - Е. Өвчтөний хамарт гараа ойртуулах
- /65./ Клиник үхэлтэй амилуулах тусламж хийгдэж байгаа өвчтөнд зүрхийг гаднаас нь шахах ажилбарын зэрэгцээ зүрхний үйл ажиллагааг сайжруулах эмийн бодисыг хийдэг. Эмийн бодисыг судсанд ямар замаар таривал хурдан үйлчлэх вэ?
- А. Захын венд
 - В. Төвийн венд \эгмэн доор, гуяны, гүрээний венд\
 - С. Артерид
 - Д. Зүрхний хөндийд
 - Е. Гарын бугалганд
- /66./ Амилуулах суурь тусламжийн үед боломжтой бол аврагчийг хэдэн минут тутамд солих вэ?
- А. 1 мин
 - В. 2 мин

- C. 3 мин
- D. 4 мин
- E. 5 мин

/67./ Анафилаксийн шокийн үеийн эмчилгээний эхний сонголт:

- A. Кальци хлорид
- B. Адерналин
- C. Димедрол
- D. Дексаметазон
- E. Анальгин

/68./ Амилуулах тусламжийн цээжний шахалт амьсгалын харьцаа хэд вэ

- A. 2:30
- B. 30:2
- C. 15:2
- D. 2:15
- E. 15:1

/69./ Аалзан бүрхэвчийн доорх цусан хураатай (САК-тай) өвчтөнгүүдэд түгээмэл тохиолддог эмнэлзүйн гол шинж аль нь вэ?

- 1. Уушиг хавагнах
- 2. Толгой гэнэт хүчтэй өвдөх
- 3. Нүд хялар болох
- 4. Тархины зөөлөн бүрхүүлийн цочролын шинж
- 5. Хурхирах

/70./ Хоёр хөлийн шилбэний хугаралтай шокийн байдалтай өвчтөнг эмнэлэгт хүргэхийн тулд зайлшгүй авах арга хэмжээ нь:

- 1. Цус алдалтыг зогсоох
- 2. Хөлийг хөдөлгөөнгүй бэхлэх
- 3. Хөлийг өндөрлөх
- 4. Шингэн сэлбэх
- 5. Өвдөлт намдаах

/71./ Стенокардийн үед нитроглицериний үйлчлэх механизм юу вэ?

- 1. Өвдөлт намдаах
- 2. Венийн судас тэлж зүрхний өмнөх ачаалал буурна
- 3. Миокардын ажлын эрчим багасна
- 4. Титэм судлас өргөснө
- 5. Катехоламины хаялт эрчимтэй буурна

/72./ Тархи нугасны шингэнийг хэдийд шинжлэх вэ

- 1. Менингийн шинж илэрсэн үед
- 2. КТГ хийсний дараа
- 3. Цус харваснаас хойш 12 цагийн дараа
- 4. Онош тодруулах зорилгоор
- 5. Тархи, нугасны хөндийн даралтыг хэмжих зорилгоор

/73./ Цус харвалттай өвчтөнийг хурдан үнэлэх Цинциннати үнэлгээ дугуйл :

- 1. Хэл яриа
- 2. Гарын хүч
- 3. Царайны илрэл
- 4. Артерийн даралт
- 5. Ухаан санааны байдал муудах

/74./ Мориноос тонгорч унасан ухаангүй хүнд таны нэн түрүүнд үзүүлэх тусламж юу вэ?

- 1. Өргөж байгаад сэгсэрнэ
- 2. Амьсгалын замыг чөлөөлж амьсгал өгнө
- 3. Цээжинд шахалт хийнэ
- 4. Хүзүүний бэхэлгээ хийж амьсгалын зам чөлөөлнө
- 5. Тусламж дуудна

/75./ Ходоод гэдэсний замын цус алдалтын үед яаралтай эхний авах арга хэмжээ:

1. Судас агшаах эм хэрэглэх
 2. Шингэн сэлбэх
 3. Хүйтэн мөс залгиулах
 4. Ходоод дурандах
 5. Блекморын гуурс тавих
- /76./ Цус ихээр алдсан шокийн байдалтай үед авах нэн түрүүний эмчилгээ:
1. Коллоид уусмал сэлбэх
 2. Ижил бүлгийн цус, сийвэн сэлбэх
 3. Допамин дусалд хийж урсгах
 4. Кристаллоид уусмал сэлбэх
 5. Адреналин судсаар тарих
- /77./ ST сегмент өргөгдсөн зүрхний шигдээсийн үед нас баралтыг бууруулдаг гурван эмийг сонго:
- A. Кальцийн сувгийн хориглогч, аспирин, гепарин
 - B. Фибринолитик бэлдмэл, бета хориглогч, гепарин
 - C. Фибринолитик бэлдмэл, нитрат, бета хориглогч
 - D. Фибринолитик бэлдмэл, АСЕ хориглогч, аспирин
 - E. "Нитрат, аспирин, гепарин
- /78./ 25 настай эрэгтэй архи их хэмжээгээр ууж, гадаа гудамжнаас унтаа байдалтай олдож ЯТТ-д хүргэгдэж ирэхэд тэрээр ухаангүй ба цулын дулаан 27.8°C ба пульс нь 40 удаа/мин байв. Дараахаас аль нь үнэн бэ
- A. Өвчтөнийг дулаацтал CPR хийнэ
 - B. QRS бүрдлийн төгсгөл хэсгийн өргөгдөл нь тавилан мууг заана
 - C. Брадикардиг судсан дотуур пейсмейкер тавьж эмчилнэ
 - D. Гипотермитэй пульсгүй өвчтөнд гадна цус эргэлтийн аппарат эмчилгээ үр дүнгүй
 - E. Гипотермитэй өвчтөнд шингэний хэмжээ буурсан байдаг
- /79./ Кроны өвчний талаарх зөв ойлголтыг сонго:
- A. Кроны өвчин үүсэхэд удамшлын хүчин зүйл хамааралгүй
 - B. Хүүхэд болон насанд хүрэгчдэд эмнэлзүй эхлэх болон эмчилгээ нь ялгаатай байдаг
 - C. Нарийн гэдэс болон бүдүүн гэдэс эсвэл 2 ууланг хамарсан гэсэн 3 хэлбэртэй
 - D. Гэдэсний өнгөц давхаргыг хамарсан үргэлжилсэн гэмтэл үүсгэдэг
 - E. Сэтгэцийн хүчин зүйл нь үүсгэх чухал хүчин зүйл болно
- /80./ Зөв гүйцэтгэж буй цээж шахалт нь цус эргэлтын хэдэн хувийг орлох вэ?
- A. 15%
 - B. 30%
 - C. 0.45
 - D. 60%
 - E. 85%
- /81./ Өвдөлттэй, цус алдаж байгаа шулуун гэдэсний эмгэгийн түгээмэл шалтгаан доорхоос аль нь вэ?
- A. Дотор шамбарам
 - B. Шулуун гэдэс урагдах
 - C. Гадна шамбарам
 - D. Бүдүүн гэдэсний цүлхэн
 - E. Шулуун гэдэсэнд гадны биет орох
- /82./ Шингэн сэлбэлтэнд тэсвэртэй гипотензитэй өвчтөнд тусламж үзүүлэхээр болов. Та альфа-адренерги бэлдмэл хэрэглэхээр шийдсэн бол дараахаас алийг хэрэглэх вэ?
- A. Дофамин
 - B. Добутамин
 - C. Амрион
 - D. Изопротренол
 - E. Фенилэфрин
- /83./ Хэвийн байрласан ихэс цагаас урьтаж ховхрохын эмнэл зүйн эхний шинж тэмдэг
- A. Хэвлийгээр өвдөнө, барихад умай өвчтэй.

- В. Цус алдатын дайрлага.
С. Ургийн бүтэлт
D. Базлалт ихэсдэг.
E. Ургийн шингэн гарна.
- /84./ Цахилгаан нь:
A. Шулуун гүйдэл
B. Хувьсах гүйдэл
C. Хувьсах болон шулуун гүйдлийн холимог
D. Хувьсах болон шулуун гүйдлийн аль нь ч биш боловч нэг чиглэлтэй цахилгаан урсгал юм
E. Цахилгаан хэлхээний онолоор тайлбарлагддаггүй
- /85./ Жирэмсний эхний гестозын үед аль шинж нь байхгүй вэ?
A. Биеийн жин буурах
B. Шээсэнд ацетон гарах
C. Артерийн даралт буурах
D. Толгой өвдөх
E. Бага зэрэг халуурах
- /86./ Гүйцэд нярай хүүхэд гэж ?
A. 0-27 хоног
B. 0-60 хоног
C. 0-30 хоног
D. 0-28 хоног
E. 0-25 хоног
- /87./ Гемморагийн шоктой өвчтөнд авах эхний арга хэмжээ?
A. Коллойд шингэнг хурдан сэлбэнэ
B. Хангалттай хэмжээгээр хүчилтөрөгч болон амьсгалаар хангана
C. Гемодинамикуыг тогтвортой барихын тулд инотропик эхлэнэ
D. Бүх урт ясны хугаралыг тогтворжуулна
E. Бүлэг тохироогүй ч цус яаралтай сэлбэнэ
- /88./ Таны өвчтөн ухаангүй, пульсгүй байгаа бөгөөд торсадо де поинт хэм алдалт байна гэж үнэлээд дефибрилятороор 1 удаа цохиулсан. Та доорх эмүүдээс алийг хийх вэ?
A. Sodium bicarbonate
B. Atropine
C. Magnesium sulfate
D. Calcium chloride
E. Epinephrine
- /89./ Сөрөг Т шүд нь ихэвчлэн ямар шалтгаанаас үүсэх вэ:
A. Ховдлын реполяризаци нь эндокардиас эпикардийн чиглэлд үүсэх
B. Ховдлын реполяризаци нь эпикардаас эндокардийн чиглэлд үүсэх
C. Ховдлын депполяризаци нь эндокардиас эпикардийн чиглэлд үүсэх
D. Ховдлын депполяризаци нь эпикардаас эндокардийн чиглэлд үүсэх
E. АВ зангилааны дамжуулалтын алдагдлаас
- /90./ Хүүхдийн зүрх зогсох голлох шалтгааныг дурдана уу.
A. Уушгины гаж хөгжил
B. Хүүхдийн уушгины төрөлхийн гаж хөгжил
C. Зүрхний гэмтэл
D. Хүчилтөрөгчийн дутмагшил
E. Дээрх бүгд зөв
- /91./ 10-р ангийн нэг ангийн 3 сурагч мухар олгойн шинжтэй иржээ . Тэдгээр сурагчдад баруун доор байрлалтай хэвлийн өвдөлт, дотор муухайрах, бөөлжих, бага зэрэг халуурах шинжтэй байв. Та үүнийг маш сонин тохиолдол гэж үзэж нутгийн яаралтай тусламжийн хэсэг рүү залгаж лавлахад мөн тийм шинжтэй 6 хүүхэд байсан ба 2 нь аль хэдийн мухар олгойн хагалгаанд оржээ. Та мухайр олгойн үрэвслээс илүү ямар эмгэгээр халдварлагдсан гэж үзэх вэ?

- A. Bacillus cereus
- B. E. coli 0157:H7
- C. Cryptosporidiosis
- D. Group D Streptococcus
- E. Yersinia enterocolitica

/92./ ЧШ Кетоацидоз бүхий өвчтөнд Куссмаулын амьсгал үүсэх шалтгаан:

- A. Цусны сахар ихсэх нь амьсгалын төвийг идэвхжүүлдэг
- B. Сийвэнгийн хүчилшил нь захын хеморецепторыг идэвхижүүлдэг
- C. Сийвэнгийн устөрөгчийн ион ихсэх нь амьсгалын төвийн рецепторыг идэвхижүүлдэг
- D. Эсийн гаднах шингэний хэмжээ буурах нь бикорбонатын реабсорбцийг ихэсгэдэг
- E. Инсулин нь амьсгалын төвийг шууд дарангуйлдаг

/93./ Торсадес де пойнт бүхий өвчтөнд хэрэглэх эм:

- A. Адерналин
- B. Лидокайн
- C. Кальци глюконат
- D. Магни сульфат
- E. Глюкоз

/94./ Ротавирусаар үүсгэгдсэн суулгалтаар өвдөх хамгийн өртөмхий бүлэг аль нь вэ?

- A. Нярай
- B. Сургуулийн өмнөх насны хүүхэд
- C. Сургуулийн насны хүүхэд
- D. Насанд хүрэгч
- E. Настан

/95./ Үрэвслийн эсрэг дааврын бус эмийн гаж нөлөө аль нь вэ?

- A. Дотор муухайрах, бөөлжих, хэвлий өвдөх
- B. Толгой өвдөх, зан төрхийн өөрчлөлт, халдварын бус менингит
- C. Таталт
- D. Бодисын солилцооны ацидоз ба бөөрний цочмог дутагдал
- E. Дээрх бүгд

/96./ Перикардийн тампонад бүхий өвчтөнд хянаж байхдаа дараахаас аль шинж нь аюултай вэ?

- A. Зүүн ба баруун ховдлын даралт тэнцүү болох
- B. зөвхөн систолийн гипертензи
- C. Цээжинд пульсацн ажиглагдана
- D. 12 холболт бүхий ЗЦБ-т R шүд намхан бичигдэнэ
- E. Митрал регургитаци

/97./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн шалтгаан болох нь аль вэ?

- A. Насанд хүрэгсдийн амьсгалын гачаалт хам шинж
- B. Миокардит
- C. Судсан дотор цус түгээмлээр бүлэгнэх
- D. Гүйлгэлт
- E. Нойр булчирхайн хуурамч уйланхай

/98./ Үжлийн шокийн талаарх зөв ойлголтыг сонгоно уу

- A. Грам эерэг бактериуд нь үжлийн шок үүсгэдэггүй учир нь тэд эсийн ханын эндотоксиноор дутмаг
- B. Лейкопени нь үжлийн шокийн шинж биш
- C. Грам сөрөг бактери болх түгээмэл шалтгаанаас хоёрдугаарт бөөр шээсний замаас үүссэн байдаг
- D. Escherichia coli нь грам сөрөг бактери болх хамгийн түгээмэл тохиолддог 2 дахь үүсгэгч юм
- E. Грамм сөрөг эндотоксины хорны нөлөө нь хэвийн физиологийн урвалыг эмгэг болгох байдаг

/99./ Титмийн артерийн эмгэгийн эрсдэлт хүчин зүйлд аль нь багтдаггүй вэ?

- A. Эр хүйс

- В. Холестрол их байх
- С. Дааврын бус үрэвслийн эсрэг эм
- Д. Чихрийн шижин
- Е. Тамхи татах

/100./ Ховдлын тахикардитай захад судас тэмтрэгдэхгүй өвчтөнд кордарон хэдэн мг хийх вэ?

- А. 150 мг
- В. 300 мг
- С. 1 мг/кг
- Д. 1.0- 1.5мг\кг
- Е. 100 мг

/101./ Их хэмжээнээр цустай баах түгээмэл шалтгаан?

- А. Улаан хоолой, ходоодны венийн судасны өргөсөл
- В. Бүдүүн гэдэсний цүлхэн
- С. Ангиодисплази
- Д. 12 хуруу гэдэсний шарх
- Е. Шамбарам

/102./ Амьсгалын дутагдалтай, амьсгалахад цээж намалзсан, гэмтсэн өвчтөнд тусламж үзүүлж байна. Өвчтөнд зохиомол амьсгал өгөх заалт нь аль вэ?

- А. Амьсгалын тоо > 25/мин
- В. Амьсгалын тоо < 12/мин
- С. $FiO_2 > 0.5$ өгч байхад $PaO_2 < 70$ mmHg байх
- Д. $FiO_2 > 0.5$ өгч байхад $PaCO_2 > 55$ mmHg байх
- Е. Цулцан-артерийн хүчилтөрөгчийн градиент > 350

/103./ Яаралтай тусламжийн тасагт чихрийн шижингийн нефропатиг оношлох хамгийн мэдрэг шинжилгээ аль нь вэ?

- А. Сийвэнгийн креатинин
- В. Сийвэнгийн мочевин
- С. Шээсний альбумин
- Д. Уургийн ачаалалтай сорил
- Е. Бөөрний эхо

/104./ Зүрхний нэвтэрсэн гэмтлийн үед тавиланд нөлөөлөх хамгийн чухал зүйл аль нь вэ?

- А. Зүрхний миокардын гэмтлийн хэмжээ
- В. Гэмтсэн хөндийн тоо
- С. Титэм судасны гэмтэл
- Д. Титмийн синусын гэмтэл
- Е. SA эсвэл AV зангилааны гэмтэл

/105./ Ухаангүй өвчтөнд хамгийн түрүүнд үзүүлэх тусламж аль нь вэ?

- А. Аюулыг зайлуулах
- В. Хариултыг шалгах
- С. Тусламж дуудах
- Д. Цээжинд шахалт хийх
- Е. Амьсгалын зам чөлөөлж амьсгал өгөх

/106./ Арьс нь хүйтэн, чийгтэй болсон уушигны цочмог хаван бүхий өвчтөн ирэв. Түүний артерийн даралт нь 84/56 мм МУБ байв. Энэхүү өвчтөнд хийх эмчилгээ юу байх вэ?

- А. Адерналин
- В. Добутамин
- С. Вазопрессин
- Д. Фенилэприн
- Е. Норадерналин

/107./ Шоктой өвчтөнг эмчлэх эмчилгээний зорилт

- А. Төвийн вений даралтыг хэвийн болгох
- В. Эдийн перфузийг хэвийн болгох
- С. Шээсний гарцыг 0.5–1.0 мл/кг/цаг

D. Артерийн дундаж даралтыг 65 мм МУБ дээш

E. Дээрх бүгд зөв

/108./ Зөгийнд хатгуулсаны улмаас хүчтэй харшлын урвал илэрсэн өвчтөнд хийх эхний эмчилгээг зөвлө?

A. Албутерол

B. Циметидин

C. Допамин

D. Адерналин

E. Норадерналин

/109./ ЯТТ-т ирж буй өвчтний гипогликемийн түгээмэл шалтгаан?

A. Чихрийн шижингийн эхэн үед

B. Архитай шалтгаантай

C. Амаар чихэр бага хэрэглэх

D. Инсулины тун хэтрүүлсэн

E. Элэгний дутагдал

/110./ Уушигны хатгалгаатай өвчтөнг үнэлэхэд хамгийн чухал нь өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэх үү эсвэл гэрээр эмчилгээ өгч хянах уу гэсэн шийдвэр байдаг. Тэгвэл уушигны хатгалгаа өвчний тавиланд хамгийн их нөлөөлөх хавсарсан эмгэг аль нь вэ?

A. Бөөрний эмгэг

B. Зүрх судасны эмгэг

C. Зүрхний төрөлхийн гажиг

D. Элэгний эмгэг

E. Хавдар

/111./ Зүрхний эмгэг болон архины талаарх зөв ойлголтыг сонго:

A. Архины архаг хэрэглээ нь рестриктив кардиомиопати үүсгэж болно

B. Хэрвээ зүрхний дутагдал үүссэн тохиолдолд архи уухаа зогсоосон ч тавиланг өөрчилж чадахгүй

C. Зүрхний төрөлхийн дутагдал нь тиамины дутагдлаас үүсдэг

D. Хэрвээ архины шалтгаант кардиомиопатитай өвчтөн архи уухаа үргэжлүүлээд байвал нас барах нь 3 жилийн дотор 70% их байдаг

E. Дээрхи бүгд зөв

/112./ 60 кг жинтэй хүнд лидокаин 1мг/кг хийхийн тулд 2% лидокаины уусмал хэдийг хийх вэ?

A. 2 мл

B. 1.5 мл

C. 1.8 мл

D. 3 мл

E. 4 мл

/113./ Хүнд хэлбэрийн цус алдалтын шокийг эмчлэхэд хамгийн чухал нь юу вэ?

A. Тохирсон цус сэлбэх

B. Төвийн венд гуурс тавьж шингэн сэлбэх болон мониторт хянах

C. Коллойд шингэнг түргэн сэлбэнэ

D. Хийлдэг өмд өмсгөх

E. Амьсгалын замыг чөлөөлж, хангалттай амьсгал өгөх

/114./ 44 настай эрэгтэй архи удаан хугацаагаар хэрэглэсэн асуумжтай хэвлийгээр хүчтэй өвдөн, бөөлжин ЯТТ-т ирсэн. АД 110/60 мм муб, захын судасны лугшилтын тоо минутанд 110 удаа, халуун 39°C, амьсгалын тоо минутанд 30 удаа, үзэхэд гэдэс хийтэй, аюулхай орчим бага зэрэг эмзэглэлтэй. Лабораторын шинжилгээнд WBC 30,000; амилаза 2,000. Хэвлийг рентгенд тойм харахад өрцний доор бага зэргийн хийтэй. Хамгийн их магадлалтай онош нь юу вэ?

A. Нойр булчирхайн цочмог үрэвсэлтэй холбоотой Маллор- Вейссийн хам шинж

B. Нойр булчирхайн цочмог үрэвсэлтэй холбоотой ходоод цоорох

C. Нойр булчирхайн цочмог үрэвсэлтэй, хоёрдогчоор 12 хуруу гэдэсний арын ханын шарх цоорох

- D. Нойр булчирхайн цочмог үрэвсэлтэй, хоёрдогчоор 12 хуруу гэдэсний өмнөд ханын шарх цоорох
- E. Нойр булчирхайн цочмог үрэвсэлтэй холбоотой гэдэсний хана ферментээр түлэгдсэн
- /115./ Халдварын шалтгаантэй суулгалтын дотор өндөр хувийг эзэлдэг шалтгаан нь:
- A. Вирус
 - B. Бактер
 - C. Шимэгч
 - D. Тодорхойгүй
 - E. Мөөгөнцөр
- /116./ Зүрх зогссон өвчтөнд венийн судсанд хүрц авахад аль нь хамгийн бага сонгодог судас вэ?
- A. Захын тохойн хонхрын вен
 - B. Эгмэн доорх вен
 - C. Гүрээний дотор вен
 - D. Шууны вен
 - E. Гуяны вен
- /117./ Захын судасны бөглөрөлтэй өвчтөнд эмболийн үүссэн гол байршил:
- A. Гол судас
 - B. Гуяны артери
 - C. Зүрх
 - D. Чацархайн артери
 - E. Тахимын артер
- /118./ Энгийн амны хошуувчаар O₂-г 8-15л/мин өгөхөд амьсгалж байгаа агаарын O₂ –ийн өтгөрөлийн дээд хэмжээ хэд вэ?
- A. 21-25%
 - B. 50-60%
 - C. 70-80%
 - D. 90-100%
 - E. 100-110%
- /119./ Геморрагийн шоктой өвчтөнд тархины цусан хангамж хэрхэн хадгалагдах вэ ?
- A. Ауторегуляци
 - B. Реактив гиперемии
 - C. Идэвхитэй гиперемии
 - D. Бодисын солилцоог ихэсгэж
 - E. Шумбах рефлекс
- /120./ 70 настай эмэгтэй хэсэг хугацааны туршид хэвлийн доод хэсгээр өвдөх болон их хэмжээгээр шулуун гэдсээр цус алдаж байна гэсэн зовиуртай ирсэн. Хамар ходоодоор зонд оруулахад цөс байсан боловч цус байгаагүй байна. Тэгвэл түүний онош аль нь байх хамгийн өндөр магадлалтай вэ?
- A. Эвэрхий
 - B. Ходоодны шарх
 - C. Дотор гемморрой
 - D. Дивертикуллоз
 - E. Чацархайн ишеми
- /121./ Төрлөгийн I үе эхэлж байгаа шинжийг хэлнэ үү.
- A. Ус гарах
 - B. умайн хүзүү төрөлтөнд бэлтгэгдсэн байх
 - C. Жигд базлалт
 - D. Ургийн толгой аарцгийн орох хэсэгт тавигдсан
 - E. Бүгд зөв
- /122./ Гипотерми бүхий ховдлын тахикардийн үед хамгийн зөв эмчилгээг сонго:
- A. Прокаинамид
 - B. Лидокаин
 - C. Амидарон

- D. Атропин
E. Аденозин
- /123./ АсАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?
A. Зүрхний шигдээс
B. Баруун ховдлын дутагдал
C. Цус задрал
D. Вирусийн халдвар
E. Бөөр болон тархины гэмтэл
- /124./ Ухаан алдаад сэргэсэн өвчтөнг үнэлэхэд хамгийн мэдрэг болон өвөрмөц шинжилгээ аль нь вэ
A. ЦДШ ба Биохимийн шинжилгээ
B. ЭКГ ба Зүрхний ЭХО
C. Толгойн КТГ ба гүрээний доплер ЭХО
D. Асуумж болон бодит үзлэг
E. Зүрхний монитор болон ортостатик байрлалд амин үзүүлэлтийг шалгах
- /125./ Хэв шинжит бус уушгины хатгалгааны эмчилгээнд доорхоос багтахгүй нь аль вэ?
A. Erythromycin
B. Azithromycin
C. Tetracycline
D. Penicillin эсвэл Cephalosporin
E. гуурсан хоолой өргөсгөгч, ханиалга дарах
- /126./ Яаралтай тусламжийн тасагт 62 настай эрэгтэй эмнэлгээс гадуурх амилуулах тусламж амжилттай хийгдэж ирсэн. Түүний өмнөх өвчний талаарх мэдээлэл байхгүй ба интубаци тавигдсан даралт хэвийн боловч перфузи хангалтгүй байв. Энэ үед хамгийн тохиромжтой эмийг сонгоно уу ?
A. Адерналин 0.05–1.0 мкг/кг/мин
B. Добутамин 5–20 мкг/кг/мин
C. Дофамин 5–10 мкг/кг/мин
D. Дофамин 2–5 мкг/кг/мин
E. Норадерналин 4 мкг/кг/мин
- /127./ 2 настай Т.С нь амьсгалгүй, ухаангүй орж ирлээ. Та хэрхэн амьсгалын замыг чөлөөлөх вэ?
A. Эрүү өргөх
B. Залгиур, төвөнх, улаан хоолойг хамгийн бага өнцгөөр огтлолцуулах
C. Чихний угалз мөрний төвшинд байх
D. Мөрөн доор ивээс хийх
E. Дээрх бүгд зөв
- /128./ 54 настай эрэгтэй яаралтай тусламжийн тасагт цээжээр өвдсөн зовиуртай ирэв. Бодит үзлэгт түүний гүрээний вен өргөссөн байсан ба уушиг цулцангийн амьсгалтай, ЗЦБ-т доод ханы цочмог шигдээс илэрсэн, артерийн даралт90/60 мм МУБ байв. Доорхоос аль эмчилгээг хийх вэ?
A. Судсаар шингэн сэлбэх
B. Норадерналин
C. Дофамин
D. Несиритид
E. Нитрофурсид
- /129./ Дараах дүрс оношилгооны шинжүүдээс аль нь зөв уялдсан байна вэ?
A. 34 настай эрэгтэйн таглаа мөгөөрсний хэсэгт эрхий хурууны дардсын шинж илэрсэн - хэлэн доорх буглаа
B. Хүүхдэд С3-ын дээрх С2 урд хэсгийн хэлбэр өөрчлөгдөх - тулгуур үений хугарал
C. “Сүмийн орой” -хэлбэрийн цагаан мөгөөрсөн хоолой хүүхдэд илрэх -эпиглотит
D. нярайд ямар нэг эмнэл зүйн шинж тэмдэггүй, хүзүүний нугаламын ойролцоох зай хавагнасан - артифакт
E. Нярай хүүхдийн гэдсэн дотор хий харагдах гэдэс чихэлдэж түгжрэх

/130./ Зүрхний гаралтай шокын үед

- A. Пропронолол
- B. Допамин
- C. Дигоксин
- D. Изадрин
- E. Эфидрин

/131./ 37 настай эмэгтэй өмнө олон архаг өвчний анамнезтэй бөгөөд одоо цочмог холециститээр оношлогдов. Та холестролын чулуу үүссэн гэвэл өмнө нь ямар өвчнөөр өвдсөн байж болох вэ?

- A. Гипертриглицеридеми
- B. Гиперхолестролеми
- C. Өмнө нь хүхэр агуулсан антибиотик ууссаны улмаас G6PD дутагдал үүсэх
- D. Хадуур эс
- E. Цутгалан гэдсийг мэс заслаар тайрах

/132./ Сургуулийн өмнөх нас хэд вэ?

- A. 3-6 нас
- B. 3-5 нас
- C. 4-6 нас
- D. 4-5 нас
- E. 4-7 нас

/133./ 4 настай хүү авто ослын улмаас хүнд хэлбэрийн амьсгалын гачаалт хам шинжид оржээ. Тэр машинаас шидэгдэж нүүр болон толгойдоо хүнд гэмтэл авсан.Түүний амьсгалын замыг хэрхэн чөлөөлөх вэ?

- A. Тохирсон хэмжээ бүхий төвөнхийн маск тавьж сорогдлын хатгаанаас сэргийлнэ
- B. Интубаци тавих эсвэл амьсгал өгж чадахгүй бол мэс заслын аргаар крикотреотоми хийхээс илүү зүүт крикотреотоми хийнэ
- C. Амьсгалын замыг бүтцүүдийг бүрэн харахын тулд хүзүүг тэнийлгэнэ
- D. Тохирсон хэмжээтэй эндотрахеал гуурсыг хамарзалгиураар оруулах аргаар баримжаалж интубаци тавина
- E. Гэмтлийн хурц үе учраас сукцинилхолин хэрэглэхээс зайлсхийнэ

/134./ Амьсгалын алкалоз бүхий өвчтөнд зохиомол амьсгалын хамгийн эхний сонголт

- A. Булчин суллах эм хэрэглэх
- B. Үлдэгдэл эзэлхүүнийг ихэсгэх
- C. Тайвшруулах
- D. Амьсгалын тоог ихэсгэх
- E. Амьсгалын тоог бууруулах

/135./ Үжлийн гаралтай шокийн байдалтай өвчтөнд нэн тэргүүнд сонгон авах эмчилгээний арга нь:

- A. Цус шүүх
- B. Коллойд сэлбэх
- C. Кристаллойд уусмал сэлбэх
- D. Допамин
- E. Норадреналин

/136./ 58 настай эрэгтэй залгихад өвдөнө гэсэн зовиуртай ирэв. Тэрээр ярих үедээ 2 эсвэл 3 удаа шүлсэндээ хахдаг өвөрмөц зуршилтай байв.Тэрээр түгшсэн байдалтай байсан бол энэхүү өвчтөнд улаан хоолойн эмгэгийн байрлал хаана байх магадлал их вэ?

- A. Ходоод улаан хоолойн залгаас
- B. Бронхын зүүн ерөнхий салаанд
- C. Духны бор гадар
- D. Тархины баганы 3 хос мэдрэлийн бөөмөнд
- E. залгиурын бөгж мөгөөрсөний түвшинд

/137./ Амилуулах суурь тусламжийг хэн үзүүлэх вэ?

- A. Эмч, сувилагч
- B. Эмнэлгийн бүх ажилчид

- С. Насанд хүрсэн бүх хүн
D. Эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын албан хаагч
E. Дэргэд нь байгаа хэн ч /бололцоотой болгон/
/138./ Ходоодонд хаймсуур тавихад доорх тохиолдлын алинд нь эсрэг заалттай вэ?
A. Улаан хоолойн цоорол сэжиглэсэн үед
B. Улаан хоолойн цоорол батлагдсан үед
C. Улаан хоолойн венийн өргөслийн асуумжтай
D. Улаан хоолойн хавдартай
E. Улаан хоолойд гадны биет байгаа
/139./ Тосгуурын жирвэлзэлтэй өвчтөн пульс 180 удаа\мин, АД 70/50 мм МУБ болсон ухаан санааны байдал муудсан. Синхрон кардиоверсийг хэдэн Джоулаар эхлэх вэ?
A. 50 J
B. 100 J
C. 200 J
D. 360 J
E. 160 J
/140./ . Насанд хүрсэн хүн яаралтай тусламжийн тасагт гипогликеми болж ирэх хамгийн түгээмэл 2 шалтгаан:
A. Диабет ба архины хэрэглээ
B. Диабет ба элэгний дутагдал
C. Диабет ба үжил
D. Элэгний дутагдал ба үжил
E. Элэгний дутагдал ба архины хэрэглээ
/141./ Сийвэнгийн К багасах шалтгаанд аль нь хамаарахгүй вэ?
A. Их шээх
B. Бөөлжих
C. Хоол тэжээлээр орох К-ийн хэмжээ багасах
D. Их хөлрөх
E. Чацга алдах
/142./ Судасны системийн ямар хэсэг нь судасны эсэргүүцлийг бүрдүүлэх вэ?
A. Аорта
B. Дунд калибрийн артери
C. Артериол
D. Капиляри
E. Вен
/143./ Доорхоос аль нь байхад венийн судасны тромбоз болж үүсэх харьцангуй эрсдэл хамгийн их вэ?
A. Таргалалт
B. Хавдар
C. С уургийн дутагдал
D. Нас > 50
E. Амаар контрацептив уух
/144./ Вений тромбоз болж өвчлөх талаарх зөв ойлголтыг сонго:
A. Уушигны эмбол нь шилбэний венийн судаснаас ихэвчлэн үүсдэг
B. Уушигны эмболийн үед илрэх хамгийн түгээмэл шалтгаан нь цустай цэр гарах
C. Уушигны эмболийн үед тохиолддог хамгийн их тохиолдох шинж нь тахикарди
D. Уушигны эмболийн ихэнх тохиолдол нь шалтгаан тодорхойгүй
E. "Вентиляция-перфузи харьцаа хэвийн байх нь оношийг үгүйсгэнэ
/145./ Гиповолемийн үед илрэх гол шинжүүдийн нэг?
A. Биеийн халуун буурах
B. Арьс хөхөрч тарлантах
C. Амьсгаадах
D. Шээс багадах
E. Зүрхний цохилт цөөрөх

/146./ Жирэмсэн үед эхлээд эхийн цусанд ямар даавар ялгарах вэ?

- A. Пролактин
- B. Эстроген
- C. Ихсийн лактоген
- D. Ихсийн гонадотрофин
- E. Бүгд

/147./ Титмийн цочмог хам шинжийн талаар зөв ойлголтыг сонгоно:

A. Тогтворгүй бах болон зүрхний цочмог шигдээс бүхий өвчтөнгүүдийн 10-аас бага хувьд нь гол зовиур нь цээжээр халуу шатах байдаг

B. Зүрхний ишемийн шалтгаантай байрлал нь тодорхой бус, битүү өвдөлт нь симпатик мэдрэлийн висцерал өвдөлтийн ширхэг цочирсоноос үүсдэг

C. Хэв шинжит зүрхний бах нь дасгал хөдөлгөөнд үе үе сэдэрдэг ба 5 минутаас удаан үргэлжилдэггүй өвдөлт нь 90%-д өвчүүний араар өвдөнө, 50%-д дамжих өвдөлт илэрдэггүй ба нитроглицеринд өвдөлт намддаг

D. Тайван үед илрэх зүрхний бах эсвэл бахын өвдөлтийн шинж чанар нь өөрчлөгдөх нь дасгалаар сэдээгддэг бахтай харьцуулахад зүрхний гэнэтийн үхлээр нас барах эрсдэл бага

E. Принцметалны бах нь зүрхний дамжуулалтын алдагдлын улмаас үүсдэг ба дасгал хөдөлгөөнд сэдэрч нитроглицеринд тэсвэртэй байдаг.

/148./ Уушигны артерийн эмболийг сэжиглэн цээжний КТГ хийхэдүг эмгэгтэй андуурагддаг хамгийн их тохиолддог эмгэг аль вэ?

- A. Уушигны хатгалгаа
- B. Таамаглаагүй перикардийн шингэн
- C. Шинэ карцинома илрэх
- D. Аортын хуулрал
- E. Пневмоторакс

/149./ Нэг удаагийн амьсгалын тохирсон эзэлхүүн:

- A. 500-600 мл орчим
- B. Биеийн жингээс хамаарна
- C. Наснаас хамаарна
- D. 6 мл/кг тооцно
- E. Өндрөөс хамаарна

/150./ Давтан төрөгчид төрлөг хэдэн цаг үргэлжлэх вэ

- A. 3-5 цаг
- B. 5-7 цаг
- C. 8-12 цаг
- D. 13-18 цаг
- E. 19-24 цаг

/151./ Удаан үргэлжлэх гипоксийн улмаас үүсэх хүндрэл:

- A. Уушигны судас тэлэгдэх
- B. Уушигны орой руу урсах уушигны цусан хамгамжийн харьцаа алдагдах
- C. Титмийн судас агших
- D. Баруун ховдлын диастолын төгсгөлийн даралт буурах
- E. Эргэлдэх цусны хэмжээг ихэсгэж зүрхний өмнөх ачаалалыг нэмдэг

/152./ ЗЦБ-т V3, V4 холболтонд ST- сегмент өргөгдсөн бол ямар артери бөглөрсөн байж болох вэ?

- A. Left circumflex
- B. Right anterior descending
- C. Right circumflex
- D. Left anterior descending
- E. Right, Left anterior descending

/153./ Тайван үед хөнгөн зэргийн баруун зүрхний дутагдалтай өвчтөн:

- A. АД бага байх
- B. Төвийн венийн даралт их байна.
- C. Зүрхний шахалтын эзэлхүүн буурна.

D. Зүрхний эргэн дүүрэлт ихсэх

E. Зүүн тосгуурын даралт ихсэх

/154./ Аортын хуулрал болон аневризмын талаарх зөв хариултыг сонго:

A. Цээжний хөндий дахь аортын хуулрал нь проксимал хэсгээс бронхиоцефаликийн эхлэл хэсэг хүртэл үргэжилсэн бол ДеБакей ангилалаар 3-р хэлбэрт ангилагдана

B. Аортын хуулралын хамгийн түгээмэл илрэлт нь санамсаргүй байдлаар цээжний рентген зураг авахад илэрдэг

C. Цээжний хүчтэй өвдөлт хөл эсвэл хэвлий рүү дамжих нь аортын хуулралын үед илрэх хамгийн түгээмэл илэрдэг зовиур юм.

D. Аортын аневризм нь аортын хуулралаас 3 дахин их тохиолддог.

E. Аортын аневризимтай харьцуулхад аортын хуулрал бүхий өвчтөнгүүд ихэвчлэн яаралтай хагалгаанд ордоггүй

/155./ Тромбоз бүхий шамбарамтай өвчтөн:

A. “Резинен боолтоор чангалах” эмчилгээ хийлгэх шаардлагатай

B. Зүслэг хийлгэж, урсгуур тавих ихэнх тохиолдолд хэрэглэнэ

C. Өөлж авах ажилбар хийлгэж дараа нь гэртээ зориулалтын уусмалд дүрэх

D. Дахиhaас сэргийлж манжин идэхээс зайлсхийх

